

КОВИДЫН ҮЕИЙН ЦАХИМ СУРГАЛТ (АШУҮИС-ийн салбар сургуулиудын жишээн дээр)

Л.Нямаа¹, Г.Сарангэрэл¹, Т.Цэрмаа, Л.Отгонтөгс³,
Н.Цэрэнлхам¹, С.Доржсүрэн¹, Ш.Отгонтуяа², Д. Баатар², Билэгмаа³, Д. Гүндэгмаа¹

¹АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны сургууль

²АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургууль

³АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургууль

Nyamaa@mnums.edu.mn

Хүлээн авсан огноо: 2021.10.21

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Б.Мэндхүү

Үндэслэл

Дэлхий нийтэд коронавирусын цар тахлын улмаас боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаа анги, танхимд явагдах боломжгүй болж улс орон бүр өөрсдийн нөөц боломжид суурилан цахим хэлбэрээр зохион байгуулж байна.

Судалгааны зорилго, зорилт

Анагаах ухааны салбар сургуулиудын ковидын үеийн цахим сургалтын байдлыг судлах зорилгын хүрээнд дараах зорилтууд дэвшүүлээ.

- АШУҮИС-ийн Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулиудын цахим сургалтын арга, хэлбэрүүдийг судлах
- Тус сургуулиудын багш нарын цахим сургалтын сэтгэл ханамжийг тодорхойлох
- Тус сургуулиудын цахим сургалтад тохиолдож буй бэрхшээлийг судлах

Судалгааны ажлын аргазүй

Ковидын үеийн цахим сургалт судалгааг АШУҮИС-ийн салбар ГАА, Дархан-Уул, Дорноговь аймаг дахь сургуулиудын багш нараас санамсаргүй түүврийн аргаар хаалттай асуумж судалгааг Google Forms судалгааны платформ ашиглан авлаа. Судалгаанд нийт 139 багшийг төлөөлүүлж 75 багшийг хамруулсан нь 54 %-ийг эзэлж байна. Судалгааны үр дүнг SPSS 21 программаар хийж гүйцэтгэв.

Судалгааны үр дүн

Судалгаанд оролцсон багш нарын 59% нь танхимын сургалт, 41% нь танхим ба цахим хосолсон сургалтыг үр дүнтэй гэж хариулсан нь анагаахын боловсрол олгох сургуульд цахим сургалт дангаараа тийм ч үр дүнтэй биш байна. Цахим сургалтын эерэг талуудыг судалж үзэхэд 88% нь олон дахин үзэх боломжтой, 84% нь орон зай хязгаарлахгүй, 77,3% нь өвчлөлөөс сэргийлэх сайн талтай гэж үзсэн байгаа ба сургуулиудаар харьцуулахад адил үзүүлэлттэй байлаа. Цахим сургалтын үр дүнд сөргөөр нөлөөлж буй хүчин

зүйлсийг 82,7% нь оюутны суралцах чадвар, 74,7% нь интернетийн хурд, чанар хүртээмж гэж хариулсныг сургуулиудаар харьцуулахад ойролцоо үзүүлэлт гарсан.

Цахим сургалт зохион байгуулах сургуулийн орчинг 62% нь дунд гэж хариулсан ба 80% нь багш нарын компьютерийн хүчин чадал муу гэжээ. Нэг удаагийн лекцийн хичээл бэлтгэхэд 7-9 цаг зарцуулдаг гэж 30,7% нь, дадлага, семинарыг нь 4-6 цаг зарцуулж бэлтгэдэг гэж хариулсныг салбар сургуулиудаар харьцуулж үзэхэд адил байлаа.

Цахим сургалтын талаар 96% нь ямар нэгэн сургалт авах хүсэлтгүйгээ илэрхийлжээ

Тухайн сэдвийн судалгааны ач холбогдол $p=0.001$ -ээс бага гарсан тул судалгааны ач холбогдолтой байв.

Дүгнэлт

АШУҮИС-ийн Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь аймаг дахь салбар сургуулийн багш нарын ихэнх хувь нь classroom, google meet ашиглан хичээлээ зааж байгаа ба цахим сургалт нь олон дахин үзэх боломжтой, орон зай харгалздаггүй, өвчлөлөөс сэргийлэх, багш хөгжих боломжтой зэрэг сайн талтай гэж үзсэн бол цахим сургалтыг үр дүнгүй болгож байгаа зүйлс нь оюутны суралцах чадвар сул, интернетийн чанар, хүртээмж муу, сургуулиудын цахим сургалт зохион байгуулах орчин хангалтгүй байна.

Ном зүй

1. БШУЯ. Дээд боловсролын хууль /шинэчилсэн хэлэлцүүлэг. УБ. 2020.
2. АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургууль. Дээд боловсролын эрин үе сэтгүүл. Дархан-Уул. 2020.
3. АШУҮИС, СБЗГ. Анагаах ухааны боловсрол судлал. УБ. 2018.
4. МАУБХ. Анагаах ухааны боловсрол сэтгүүл. УБ. 2011.
5. АШУҮИС. Сургалтын бодлого, зохицуулалтын журам. УБ. 2020.